

# Эрх зүйн ойлголт, мөн чанар

**БАГШ:Д.ОЮУН**

# Сэдэв 10: Эрх зүйн ойлголт, мөн чанар

Сэдвийн зорилго: Эрх зүй амьдралд хэрхэн нөлөөлдөг, түүний онцлог, эрх зүйн тухай ойлголт болоод түүний хэлбэр, бүрдүүлэгч гол элементүүдийн талаар цэгцтэй мэдлэг олж авахад оршино.

# Түлхүүр үгс:

- Эрх зүй
- Хэрэгцээ
- Ашиг сонирхол
- Эрх ашиг
- Ром герман
- Англи-Саксоны
- Зан заншлын ба шашны
- Тунхаглал
- Конвенц, факт
- Протокол
- Хууль
- Эрх зүйн онол
- Санкци
- Гипотез
- Диспозици

# Эрх зүй гэдэг нь

Эрх зүй (law) – хүний жам ёсны эрх, эрх чөлөө, шударга ёсыг бэхжүүлэн хамгаалж, нийтлэг хүсэл зоригийг илэрхийлж, нийгмийн харилцааг зохицуулахын тулд төрөөс зөвшөөрсөн буюу тогтоосон, төрийн албадлагаар хамгаалагдсан, бүх нийтээр заавал дагаж хэрэгжүүлбэл зохих хэм хэмжээнүүдийн тогтолцоо юм.

Нийгмийн харилцааг хамгаалах, зохицуулах зорилгоор уг харилцаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлно.

- Эрх зүйн онол нь хууль зүйн тулгуур шинжлэх ухаанд хамаарагдана.
- Эрх зүйн онолын үндэслэл, зарчмыг танин мэдэхгүйгээр хууль зүйн тодорхой мэдлэгийг эзэмших ямар ч аргагүй. Эрх зүйн онол бол хууль зүйн шинжлэх ухааны суурь мэдлэг эзэмших үндсийн үндэс мөн

1. Эрх зүйг төрөөс тогтоодог. (УИХ)
2. Төр эрх зүйг хамгаалдаг
3. Эрх зүй нь өөрийн гэсэн илрэх хэлбэртэй. Энэ нь эх сурвалж болж байдаг  
Үүнд: хууль, зарлиг, захирамж шийдвэр гэх мэт.
4. Эрх зүй нь хэсэг хэсгээр нийлж үндэсний эрх зүйн системийг бүрдүүлдэг.  
Үндэсний эрх зүйн систем нь Салбар эрх зүй, институтэд хуваагдана.

*Салбар эрх зүй нь:*

Хөдөлмөрийн эрх зүй

Гэр бүлийн эрх зүй

Эрүүгийн эрх зүй

Захиргааны эрх зүй

Иргэний эрх зүй зэрэгт хуваагдана.

- **Хэрэгцээ**-Тухайн субъектын чөлөөтэй эрэлт, шаардлага
- **Ашиг сонирхол**-Хэрэгцээ ухамсарлаж, түүнийг хангах арга замыг илэрхийлсэн зайлшгүй байдал
- **Эрх ашиг**-Хуульчлагдсан ашиг сонирхол

# Эрх зүйн чиг үүрэг

Нийгмийн харилцаанд эрх зүйн нөлөөлөх үндсэн чиглэлийг эрх зүйн чиг үүрэг гэнэ.

Энэ нь эрх зүйн зорилгыг хангахад чиглэгдсэн хууль зүйн нөлөөллийн хүрээлэл

# Эрх зүйн зарчим

Зохицуулалтанд баримтлах хууль зүйн үндсэн чиглэл

Хууль ёсны - Олон улсын  
эрх зүйн хэм хэмжээнээс үндэсний  
хууль тогтоомжинд тусгагдан  
хуульчлагдсан зарчмууд

Жам ёсны - Хүний язгуур эрх  
ашгийг тусгасан,  
хуульчлагдаагүй боловч  
төрөөс хамгаалагдсан зайлшгүй  
зарчим

# Эрх зүйн түүхэн тогтолцоо

## Ром германы тогтолцоо

Хууль цаазын шинжлэх ухааны үндсэн зорилго нь зохицуулалт хийхийн тулд зөв зүйтэй хэм хэмжээг хайх явдал гэж үздэг. Иймээс эрх зүйн акт буюу хуулийг чухалчилдаг. Ромын эрх зүйн рецепцийн шууд нөлөөн дор явагдсан гэж хэлж болно. Ромын эрх зүйн рецепцийг хэрэгжүүлэхэд европын Их сургуулиуд маш чухал үүрэг гүйцэтгэсэн. Их сургуулиудад зааж байсан эрх зүй нь тухайн үед хэрэгжиж байсан эрх зүй биш, харин XI зууны сүүлчээр Италийн нэгэн номын сангаас илрүүлсэн 534 оны үед Ромын Юстиниан хааны дэргэд бүрдүүлсэн хуулийн эмхэтгэлтэй холбоотой байсан юм.

# Англи-Саксоны эрх зүйн тогтолцоо

Англи-Америкийн эрх зүйн аймгийн хөгжил XVIII зууныг хүртэлх Английн эрх зүйн түүхээс хамааралтай болох нь нийтээр хүлээн зөвшөөрөгдөөд байна. Английн эрх зүй нь одоогийн Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улс (ИБУИНВУ)-ын нутаг дэвсгэрийг бүхэлд хамардаггүй бөгөөд зөвхөн Англи, Уэлсэд үйлчилж, ИБУИНВУ-ын бүрэлдэхүүн хэсэг болох Шотланд, Умард Ирландад хамааралгүй байдаг. Английн эрх зүйн түүхийг 1066 оны Нормандын булаан эзлэлтээс Тюдорын үе (1485) буюу Нийтлэг эрх зүй (common law) бүрэлдэн тогтсон үе. Нийтийн эрх зүйн үндсэн хэсэгт жишгийн эрх зүй (прецедент) юм. Мөн Жишгийн эрх зүйгээс гадна шударга ёсны эрх зүй (equity) үүсэн бий болж зэрэгцэн оршиж байсан үе (1485-1832), 1832 оноос өнөөг хүртэлх үе гэж гурван үндсэн үечлэлд хувааж үздэг байна.



# Зан заншлын ба шашны эрх зүйн тогтолцоо

Хүмүүсийн харилцааны журмыг аль нэг шашинд нийцүүлэн тогтоосон эрх зүй.



Хоёр буюу хэд хэдэн улс, олон улсын эрх зүйн бусад субъектүүд улс төр, эдийн засгийн болон бусад харилцаанд тэдгээрийн хооронд харилцан эрх, үүрэг тогтоох буюу эсхүл өөрчлөх буюу эсхүл дуусгавар болгох хэлэлцээр олон улсын гэрээний олон улсын эрх зүйн үндсэн эх сурвалж болдог.

### **Тунхаглал**

Тунхаглал нь хуульчлан дагаж мөрдөх албагүй, зөвлөмж, уриалгын Шинжтэй баримт бичиг.

### **Конвенц, пакт**

Конвенц, пакт нь хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ.

### **Протокол**

Протокол нь хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичиг.

# Эрх зүйн чиг үүрэг

Нийгмийн амьдралын хүрээнд нөлөөлж байгаа байдал чиглэлээр нь:

- **Эдийн засгийн чиг үүрэг.** Энэ нь зах зээлийн эрэлт шаардлага, өмчийн зайлшгүй байдлыг харгалзан эдийн засгийн голлох харилцааг зохицуулж нөлөөлөхөд үйлчилнэ.

- **Улс төрийн чиг үүрэг.** Энэ нь тухайн түүхэн цаг үед дэвшигдсэн улс төрийн бодлого, зорилтыг хангаж, ард түмний тулгамдсан амин чухал эрх ашгийг хамгаалахад чиглэгдэнэ.



- **Экологийн чиг үүрэг.** Энэ нь байгаль орчныг хамгаалах, дэлхийн дулааралтай тэмцэх, цаг агаар, байгалийн онцгой үзэгдлийг даван туулахад эрх зүйн нөлөөлөл үзүүлж, өөрийн зорилгыг хангана.
- **Ёс суртахуун, оюун санааны чиг үүрэг.** Энэ нь хүмүүсийн харилцааны соёл, биеэ авч явах, хоорондоо харилцах ердийн горим журмыг тогтоох, хамгаалах, эрх зүйг танин мэдэх, ухамсарлах, хуулийг хүндэтгэхэд чиглэгдэнэ.



- **Социаль буюу нийгмийн чиг үүрэг.** Энэ нь хүмүүнлэгийн зорилгыг хангахад үйлчлэх бөгөөд нийгмийн социаль хүрээнд идэвхтэй нөлөөлөх замаар тус дөхөм үзүүлнэ.
- **Техник технологийн чиг үүрэг.** Энэ нь мэдээллийн технологийн ололт, үр дүнг ашиглах замаар интернетийн орчинд эрх зүйн нөлөөллийг үзүүлж үр ашигтай, үнэн зөв мэдээ, мэдээллийг шуурхай, цаг тухайд нь хүргэхэд чиглэгдэнэ.

# Эрх зүйн үндсэн гол зарчмууд нь:

## 1. Хүнлэг ёсны зарчим.

Энэ нь хүн төрөлхтний хамгийн үнэт зүйлс болсон хүнийг хайрлан хүндэтгэх, хамгаалж, хөгжүүлэхэд энэ зарчмын мөн чанар оршино. Энэ нь хүний хүсэл хэрэгцээ, эрэлт шаардлагад нийцүүлж, хүний амин чухал эрх ашиг, нэр төр, алдар хүнд, ашиг сонирхол, халдашгүй чөлөөт байдлыг хамгаалж, хүний эрхийг хүндэтгэх үндсэн дээр үйлчилнэ.

## 2. Нийгмийн эрх чөлөөг хангах зарчим.

Энэ нь нийгмийн харилцаанд оролцогчдод өргөн эрх, эрх чөлөөг олгохгүйгээр эрх зүйн зохицуулалт хийх ямар ч боломжгүй. Энэ нь субъектив эрхийн илэрхийлэл болдгоороо хувь хүний төдийгүй бусад субъектын эдлэх нийтлэг эрх, түнийг хангах бодит боломжоор тодорхойлогдоно.

# Эрх зүйн хамгаалах чиг үүрэг

- Эрх зүйн хэм хэмжээг зөрчихгүй байх хэвийн найдвартай нөхцөлийг хангах
- Эрх зүйн харилцаанд оролцогчдын даган биелүүлэх хэм хэмжээг тогтоох
- Эрх зүйн хэм хэмжээ зөрчигдсөн үед зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох
- Эрх зүйн зөрчлөөс учирсан хохирол, үр дагаврыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх
- Эрх зүйн зөрчлөөс үүссэн хэрэг маргааныг таслан шийдвэрлэх
- Эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн буруутай этгээдэд цээрлэл, зэмлэл үзүүлэх гэх МЭТ

# Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүрэг

## **Хүндэтгэх**

Хүн бүр эрхээ эдлэхэд саад учруулахгүй байх, төрийн зүгээс ялгаварлан гадуурхахгүй байх

## **Хангах**

Хүн бүр эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх, эрх зүй, нийгмийн нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах

## **Хамгаалах**

Бусад хүн, байгууллага хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх зөрчигдвөл сэргээн эдлүүлэх

## **Ахиц дэвшил гаргах**

Хүний эрхийн талаар олсон ололт амжилтаа бататгаж,ямагт ахиц дэвшил гаргах

# Эрх зүйн хэм хэмжээний акт.

Энэ нь төрөөс тогтоож, зөвшөөрсөн төрийн албадлагаар хамгаалагдсан, заавал биелэгдэх шинжтэй хэм хэмжээнээс бүрдсэн албан ёсны хуульзүйн баримт бичиг юм. Эрх зүйн хэм хэмжээний актад:

- Үндсэн хууль
- Хууль
- Хуульчилсан акт зэрэг хамаарна.

**Эрх зүйн эх сурвалж** нь тухайн улс оронд үйлчилж байгаа эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэх ба илэрхийлэх албан ёсны хэлбэр мөн. Эрх зүйн дараах хэлбэрийн эх сурвалж байдаг.

Үүнд:

- Эрх зүйн зан заншил
- Шүүхийн прецедент
- Эрх зүйн хэм хэмжээний акт
- Норматив агуулгатай гэрээ зэрэг болно.

## Сэтгэл зүйн онол (Л.И.Петражицкий, Дьюг, Мэрилла, Росса)

Эрх зүй нь нийгмийн сэтгэц-ёс зүйн бүрэлдэхүүн. Эрх зүй нь нийгмийн ёс зүйн ухамсарт тулгуурласан журамт үүрэг, сэтгэл зүйн боломж бүхий хүмүүсийн биеэ авч явах байдлын дадал заншлын хэм хэмжээнүүд юм. Эрх зүйн хэм хэмжээ хүмүүсийн ухамсар, сэтгэл зүйн хүчин зүйлээр дамжин хүсэл зоригийн илэрхийлэл болдог учраас нийгмийн хүсэл, хэрэгцээг хангахад үйлчилдэг.



## Социологийн чиглэлийн онол (Эрлих, Муровцев, Паунд)

Эрх зүй гэдэг бол хүмүүсийн зүй ёсны зан үйлд тулгуурласан хууль зүйн шинжтэй харилцааны цогц. Эрх зүйг зөвхөн хэм хэмжээ байдлаар тодорхойлох нь зохимжгүй бөгөөд түүний амьдралд хэрэгжсэн байдал гэж үздэг.



## Эрх зүйн онолын реалист чиглэл (Р.Иеринг)

Эрх зүй нь төрөөс хүлээн зөвшөөрч, хамгаалсан ашиг сонирхол юм. Энэхүү ашиг сонирхол нь эрх зүйн харилцаанд оролцогчдод ашигтай бөгөөд тэдний хэрэгцээг хангахад чиглэгддэг учраас зайлшгүй биелэгдэх шинжтэй. Эрх зүй нь мөнхийн хөдөлгөөнгүй үзэгдэл биш, нийгмийн хөгжил, хөдөлгөөнд байж, тухайн цаг үеийн эрэлт хэрэгцээг тусгадаг.





## **Жам ёсны буюу төрөлхийн эрхийн онол (Дж.Локк, Ж.Руссо, Ш.Монтескье, Радащев)**

Үүний анхны үзэл санаа нь нэн эрт үеэс эхлэлтэй юм. Орчин үед уг онолын чиглэл нөлөөтэй хэвээр байгаа юм. Эрх зүй нь төрөөс тогтоосон хэм хэмжээнээс гадна хүний заяамал эрх чөлөөнөөс эх үндэстэй төрөлхийн эрхийн хэм хэмжээтэй нийцсэн байх ёстой гэж үздэг.



## Материалист чиглэл (Марксист-ленинист онол, К.Маркс. Энгельс, В.И.Ленин)

Эрх зүй гэдэг нь нийгмийн материаллаг амьдралын нөхцөлөөр тодорхойлогдсон, эдийн засгийн талаар ноёрхогч ангийн хууль болгон өргөмжлөгдсөн хүсэл зоригийн илэрхийлэл гэж тодорхойлдог. Эрх зүйн мөн чанар нь түүний ангийн шинж, материаллаг нөхцөлөөс эх үндэстэй байдагт оршино.



## Судалгааны үндсэн аргууд нь:

1. Харьцуулалтын арга. Энэ нь эрх зүйн онолын танин мэдэхүйн тухайн объектыг бусадтай нь буюу дотоод бүрдэл хэсгүүдтэй нь зэрэгцүүлэн жишиж, адил төстэй баялгаатай шинжийг илрүүлэн, хоорондын хамааралт харьцааг тогтоох замаар судалдаг арга.
2. Түүхчлэн судлах арга. Эрх зүйн тодорхой асуудлыг түүхэн цаг үеийн нөхцөлд нь, хөгжлийн зүй тогтолын талаас нь судалдаг арга.

3. Формаль-логикийн арга. Эрх зүйн танин мэдэхүйн объектыг зүй тогтолт төлөв байдал нь буюу шалтгаант холбоо, үндэслэлт шинжээр нь судалдаг арга. Үүнд анализ, синтез, индукци, дидукц гэх мэт
4. Социологийн арга. Нийгмийн амьдралыг бодит байдалд нь эмпирик туршилтын замаар судалдаг арга.

5. Хийсвэрлэн сэтгэх арга. Эрх зүйн асуудлыг танин мэдэхүйн сэтгэлгээний түвшинд загварчлан гаргах, тодорхойлон томъёолж судлах арга.
6. Диалектик хандлагын арга. Эрх зүйн үзэгдлийг хөгжил хөдөлгөөнд нь бусад үзэгдэлтэй салшгүй холбоотой шинжээр нь судалдаг арга.

7. Системд хандлагын арга. Эрх зүйн үзэгдлийг эрэмбэ дараалалтайгаар тодорхой бүрдэл хэсгийн тогтолцоонд нь судалдаг арга.
8. Интеграци-дифференциацийн арга. Энэ нь тухан объектыг бусдад нь нэгтгэх буюу бусдаас нь зааглан тусгаарлах замаар судалдаг арга.

*Эрх зүй гэдэг нь* бүх нийтээр дагаж мөрдөх, төрөөс тогтоосон ба түүнийг албадлагын хүчээр хангагдаж байдаг нийгмийн хэм хэмжээний тогтолцоо юм. Эрх зүй нь бүхэл ойлголт ба дотроо эрх зүйн хэм хэмжээнд шилжинэ. Эрх зүйн хэм хэмжээ нь хууль ба хуульчилсан актад задарна.

*Хууль гэдэг нь:* төрийн эрх бүхий байгууллагаас зохих журмын дагуу батлан гаргасан дээд хүчин чадалтай акт юм.

Аливаа улсын хууль үндсэн хуулиндаа тулгуурлан тогтоогддог ба бусад хууль болон хуульчилсан акт нь үндсэн хуулиндаа нийцэж хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх ёстой.

Үүний учир шалтгааныг бодож үзвэл

1. Хууль тогтоомжийг УИХ гаргадаг
2. УИХ-ыг ард түмэн буюу бид өөрсдөө сонгодог.

Хууль бол нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулагч төрийн чухал баримт бичиг. Энэ нь зохицуулах зүйл аргын онцлогоос хамаарч дараах ангилалд хуваагдана

**Нэг бүрчилсэн хууль** гэдэг нь нийгмийн харилцааны болон төрийн байгууллын хуульчлах ёстой тодорхой асуудлыг шийдвэрлэх буюу түүний хэрэгжилтийн баталгааг хангахад чиглэгдсэн байна.

**Органик хууль** нь үндсэн хуульд тухайлан заасан тодорхой заалтанд үндэслэн түүнийг хэрэгжүүлэх болон тодорхой эрх бүхий субъектийн зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоох замаар гарсан хууль

**Төрөлжсөн хууль** нь нийгмийн харилцааны тодорхой хүрээг зохицуулагдахад чиглэгдэнэ.

**Функционал хууль** энэ нь эрх зүйн зөрчлийн хэрэг маргааныг шийдвэрлэх буюу хууль зүйн үр дагавар бүхий тодорхой тохиолдлыг эрх зүйн процедурыг хангах замаар шийдвэрлэхэд чиглэгдсэн хуулиуд юм.

**Онцгой хууль** нь улс орны үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, нийгэмд онцгой байдал бий болсныг зохицуулан журамлах зорилгоор цаг үеийн шинжтэй гарсан хуулийг оруулдаг.

Эрх зүйн зохицуулалтын олон аргуудтай. Үүнд:

1. Императив буюу захирамжлах арга
2. Диспозитив буюу зөвшилцөх арга
3. Урамшуулах арга
4. Талуудын эрх тэгш, хараат бус байдлын арга
5. Зөвлөсөн арга
6. Итгүүлэн үнэмшүүлэх, албадлах арга

# Эрх зүйн зохицуулалтын арга нь:

## *Императив арга:*

Энэ нь хориг, үүрэг, шийтгэлд үндэслэсэн захирамжлах, захирах, захирагдах заалтын шинжтэй байдаг. Эл аргыг гол төлөв, эрүүгийн захиргааны болон бусад салбар эрх зүйд ашиглагдана.

## *Диспозитив арга:*

Энэ нь талуудын зөвшилцөх, харилцан тохиролцоход үндэслэсэн эрх тэгш байдлаар илэрнэ. Энэ аргын онцлог шинж нь субъектүүд хуулийн хүрээнд зан үйлийн хувилбараар сонгох боломжийг бүрдүүлсэн байдаг. Энэ нь иргэний болон худалдааны эрх зүйд хэвшмэл байна.

## *Урамшуулалын арга:*

Энэ нь тодорхой сайн зан үйлийг хөхүүлэн дэмжихэд чиглэгдэнэ. Энэ аргыг хөдөлмөрийн эрх зүйд өргөн хэрэглэнэ. Цалин урамшуулалт гэх мэт

## *Зөвлөмж болгосон арга:*

Уг арга нь гол төлөв хөдөө аж ахуйн эрх зүйд өргөн хэрэглэгдэх бөгөөд төрөөс малчид, фермер, хөдөө аж ахуйн бусад байгууллагад зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх байдлаар илрэн гарна.

Эрх зүйн хэм хэмжээний бүтцийг логик бүрдэл хэсгийн шинжээр  
нь гипотез, диспозици, санкци гэж ангилна.

**Гипотез**/нөхцөл заасан хэсэг/ аливаа эрх зүйн хэм хэмжээний үндэслэл тухайн заалтын урьдчилсан нөхцөл боломжийн хэр хэмжээг тодорхойлсон хэсэг юм.


**Диспозици** /заалт хэсэг/ энэ нь эрх зүйн харилцаан оролцогчдын зан үйлийн хэмжээ хязгаарыг заасан заалтууд юм. Өөрөөр хэлбэл тухайн хэм хэмжээний агуулгын бүтцийг тодорхойлсон хэсэг юм. Диспозицийг эрх олгосон, үүрэг олгосон, хориглосон, зөвшөөрсөн гэж 4 ангилна

Туйлын тодорхой **санкци** гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний тодорхой нэг төрлийн буюу нэг мөр хариуцлага заасан хэсэг юм. Харьцангуй тодорхой санкци гэдэг нь хариуцлага заасан хэд хэдэн заалт хамтдаа хэрэглэгдэхээр тусгагдсаныг хэлнэ.




## Хяналтын асуулт, даалгавар:

- 1. Эрх зүй, төрийн онолыг эрх зүйн сургалтад суурь хичээл байдлаар чухалчилан авч үздэг сургалтын уламжлал аль үндэсний эрх зүйгээс үүсэлтэй вэ?**
  - а. Германы эрх зүй.
  - б. Английн эрх зүй.
  - с. Оросын эрх зүй.
  - д. Америкийн эрх зүй.
  - е. Францын эрх зүй
- 2. Эрх зүйн хэм хэмжээг зохицуулах шинжээр нь**
  - а. Зохицуулах ба хамгаалах.
  - б. Хамгаалах ба бэхжүүлэх.
  - с. Императив ба диспозитив.
  - д. Ерөнхий ба тусгай
- 3. Эрх, үүрэг үүсэх нөхцөл заасан хэсэг**
  - а. Сонгох диспозиц.
  - б. Харьцангуй тодорхой санкци.
  - с. Гипотез.
  - д. Диспозиц.
  - е. Санкци
- 4. Эрх зүйн сурвалж гэж юу вэ, түүний бүрдүүлэгч?**
- 5. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүрэг байдаг вэ? Түүний онцлог?**



## Эх сурвалж:

1. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
2. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014
3. Д.Баярсайхан “Эрх зүйн онол” ., УБ., 2000 он.
4. Б.Минжүүрдорж “Эрх зүйн онол” УБ., 2010 он.



**Анхаарал хандуулсанд баярлалаа.**

